

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Арбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/20/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Хөвсгөл аймаг
2023 он

Хөвсгөл аймаг Төрийн Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Аудитор: Л.Мандахнаран
Утас: 92118277 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
4.1 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт.....	17
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.27 № 01/299
танай _____ -ны № _____ -Т

АРБУЛАГ СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ Б.ГАНТУЛГА
ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Арбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Арбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэн нэгтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Хоршоо хөгжүүлсэн сангийн авлагын үлдэгдэл 254.0 сая төгрөг байна. Үүнээс 18 иргэний 113.5 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Арбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч Хөвсгөл аймгийн Засаг даргатай тайлант онд 8 чиглэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллахаар гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг 86.4 хувиар дүгнүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,101,550.7	460,605.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	238,334.7	125,166.1
33	АВЛАГА	151,357.6	205,177.5
34	УРЬДЧИЛГАА	0.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	711,858.4	130,262.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,667,732.7	1,280,065.3
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	51,214.4	56,452.0
37300	Урт хугацаат зээл	51,214.4	56,452.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,616,518.3	1,223,613.3
39200	Биет хөрөнгө	3,383,073.8	1,137,566.6
39300	Биет бус хөрөнгө	233,444.5	86,046.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,769,283.4	1,740,671.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	876.0	74.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	876.0	74.4
41300	Өглөг	876.0	74.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,768,407.4	1,740,596.8
51	Засгийн газрын хувь оролцоо	4,768,407.4	1,740,596.8
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,800,066.4	1,082,703.3
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,800,066.4	1,082,703.3
51200	Хуримтлагдсан үр дүн	844,820.9	366,607.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,123,520.0	291,286.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,769,283.4	1,740,671.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,990,017.0	1,462,361.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	198,841.8	332,718.4
110	Орлогын албан татвар	61,376.3	200,225.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	61,376.3	210,072.3
1103	ААН-ын орлогын албан татвар	0.0	-9,846.5
113	Хөрөнгийн албан татвар	100,492.4	63,213.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	36,973.2	69,279.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	525,695.2	273,927.2
120	Нийтлэг татварын бус орлого	525,695.2	273,927.2
121	Хөрөнгийн орлого	0.0	0.0
122	Тусламжийн орлого	0.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,265,480.0	855,716.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,641,144.0	1,312,104.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,641,144.0	1,124,346.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,920,192.3	936,583.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,777,016.4	429,416.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	239,085.9	54,225.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,965.1	122,468.3
2104	Хангамж, бараа материалын зардал	136,753.5	51,954.6
2105	Нормативт зардал	327,304.1	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,158.8	39,469.6
2107	Томилолт, зочны зардал	2,757.7	1,280.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,692.6	18,646.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	316,458.2	219,121.8

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	720,951.6	187,763.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	187,758.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	348,873.1	150,257.2
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	743.1	730.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	54,735.1	3,146,107.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	294,881.1	-2,995,120.2

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,531,586.3	1,241,482.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	198,841.8	332,718.4
110	Орлогын албан татвар	61,376.3	200,225.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	61,376.3	210,072.3
1103	ХХОАТ-ын буцаалт орлогын албан татвар	0.0	-9,846.5
113	Хөрөнгийн албан татвар	100,492.4	63,213.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	36,973.2	69,279.3
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,904.7	6,704.0
1181	Газрын төлбөр	531.4	2,073.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	31,537.1	60,502.3
1183	Бусад татвар	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	99,905.8	53,047.5
120	Нийтлэг татварын бус орлого	99,905.8	53,047.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,232,838.7	855,716.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,209,071.5	1,030,692.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,209,071.5	1,030,692.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,484,275.9	730,336.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,775,128.3	412,267.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	240,848.4	50,550.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	110,271.0	124,978.3
2104	Хангамж, бараа материалын зардал	123,972.7	36,583.3
2105	Нормативт зардал	117,794.4	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,527.9	31,759.6
2107	Томилолт, зочны зардал	2,966.0	1,280.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,281.4	37,795.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,485.6	35,120.8
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	724,795.6	300,356.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	322,514.8	210,789.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	156,209.8	188,958.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	156,209.8	188,958.4
2200	Дотоод эх үүсвэрээр	156,209.8	188,958.4
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-156,209.8	-188,958.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-135,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	135,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	166,305.0	-113,168.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	72,029.7	238,334.7

20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	238,334.7	125,166.1
----	--	------------------	------------------

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,472,400.0	4,472,400.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	7,683.6	7,683.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,480,083.6	4,480,083.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-6,320.2	-6,320.2
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-237.1	-237.1
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	294,881.1	294,881.1
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,768,407.4	4,768,407.4
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,768,407.4	4,768,407.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-32,690.4	-32,690.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,735,716.9	4,735,716.9
19	Тайлант үеийн үр дүн	-2,995,120.2	-2,995,120.2
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,740,596.8	1,740,596.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,509,502.90	1,326,473.95	183,028.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,092,408.00	1,003,715.58	88,692.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	730,017.00	722,996.65	7,020.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	415,857.30	410,167.43	5,689.87
210101	Үндсэн цалин	386,985.30	321,109.59	65,875.71
210102	Нэмэгдэл	7,990.00	51,385.90	-43,395.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00	0.00
210104	Урамшуулал	10,482.00	28,962.04	-18,480.04
210105	Гэрээт ажлын хөлс	10,400.00	8,709.92	1,690.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,946.70	50,550.70	396.00
210201	Тэтгэврийн даатгал	34,704.30	34,435.10	269.20
210202	Тэтгэмжийн даатгал	4,082.70	4,050.99	31.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,142.30	3,116.97	25.33
210204	Ажилгүйдлийн даатгал	920.20	913.86	6.34
210205	Эрүүл мэндийн даатгал	8,097.20	8,033.78	63.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,010.50	124,978.32	32.18
210301	Гэрэл, цахилгаан	25,076.90	27,070.27	-1,993.37
210302	Түлш, халаалт	96,660.00	97,025.00	-365.00
210303	Цэвэр, бохир ус	3,273.60	883.04	2,390.56
210304	Байрны түрээс	0.00	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,355.00	30,337.00	18.00
210401	Бичиг хэрэг	2,315.40	2,385.40	-70.00
210402	Тээвэр, шатахуун	22,169.60	22,099.60	70.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,500.00	3,500.00	0.00
210404	Ном, хэвлэл	120.00	102.00	18.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200.00	1,200.00	0.00

Арбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,050.00	1,050.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,053.10	32,959.60	93.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,200.00	1,200.00	0.00
210604	Урсгал засвар	31,853.10	31,759.60	93.50
2107	Томилолт, зочны зардал	1,280.00	1,280.00	0.00
210702	Дотоод албан томилолт	1,280.00	1,280.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,232.40	37,695.90	536.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,674.40	35,223.10	451.30
210803	Даатгалын үйлчилгээ	220.00	191.85	28.15
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250.00	247.01	2.99
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88.00	33.94	54.06
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000.00	1,000.00	0.00
210807	Газрын төлбөр	1,000.00	1,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,282.00	35,027.70	254.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,162.50	29,162.50	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,119.50	5,865.20	254.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	362,391.00	280,718.92	81,672.08
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	334,610.50	252,938.44	81,672.06
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	334,610.50	252,938.44	81,672.06
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,780.50	27,780.48	0.02
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	21,980.50	21,980.48	0.02
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,800.00	5,800.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	200,000.00	187,758.37	12,241.63
223001	Бусад хөрөнгө	200,000.00	187,758.37	12,241.63
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	217,094.90	135,000.00	82,094.90
230001	Эргэж төлөгдөх зээл	217,094.90	135,000.00	82,094.90
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,509,502.90	1,229,502.76	280,238.14
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	109,410.50	229,410.50	-
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	109,410.50	229,410.50	-
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,060,445.30	953,479.26	106,966.04
320001	Орон нутгийн төсвөөс	1,060,445.30	953,479.26	106,966.04
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	339,647.10	46,612.51	293,272.09
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	130,434.00	43,612.51	86,821.49
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000.00	3,000.00	0.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	206,213.10		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	116,707.09	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	2,005.46	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,989.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,989.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,539.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,100.0
210104	Урамшуулал	2,100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	6,246.3

Арбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	70.0
210402	Тээвэр, шатахуун	2,046.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	93.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	450.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	450.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	450.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,989.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,989.4
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,100.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,580.4
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	309.0
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Арбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Хөвсгөл аймгийн Арбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

Тус сумын Засаг дарга нь нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 86.4 хувьтай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй. Тус төвлөрүүлэн захирагчийн харьяанд байгаа байгууллагууд нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль, Татварын багц хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна.

Тус төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нийт 2 байгууллага, орон нутгийн 2 сан, Ерөнхий орлогын данс, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн хаалтын санхүүгийн тайланг нэгтгэсэн байна. Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулжээ. Засгийн газрын 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан тул Арбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгийг улсын төсөвт шилжүүлсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас нэгдсэн байдлаар боловсруулан мөрдүүлж байна. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд томоохон өөрчлөлт ороогүй байна. Тайлант онд шинээр Төсвийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлсэн.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Арбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх орон тооны бус дотоод хяналтын нэгжийг Засаг даргын 2022 оны А/03 тоот захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан байна.

Дотоод хяналтын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын нэгжийн гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод хяналтын нэгжээс шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Арбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-д нийцүүлэн нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ. Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Арбулаг сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,028.6 сая төгрөгөөр буурсан нь байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	223.5	125.2	-113.1
Авлага	151.3	205.1	53.8
Бараа материал	711.7	544.1	-231.0
Урт хугацаат хөрөнгө оруулалт	51.2	56.5	5.1
Үндсэн хөрөнгө	3,616.5	1,223.6	-2,392.9
Нийт хөрөнгө	4,769.3	1,740.7	-3,028.6
Өр төлбөр	0.9	0.1	-0.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,768.4	1,740.6	-3,027.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,769.3	1,740.7	-3,028.6

Эх сурвалж: Арбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө данс өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө, бараа материал данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө данс нь ОНХС-ийн 0.06 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн 1.9 сая төгрөг, орон нутгийн давсан орлого болон орон нутгийн төсвийн байгууллагуудын төвлөрүүлсэн орлого 123.2 сая төгрөг нийт 125.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Дээрх мөнгөн хөрөнгө нь Төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.
- Авлага 53.8 сая төгрөгөөр өсөж 205.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд Хоршоо хөгжүүлсэн сангийн зээлийн авлагын үлдэгдэл 197.5 сая төгрөг, зээлийн хүүгийн авлага 7.6 сая төгрөг байна. Үүнээс 18 иргэний 113.5 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт хугацаа хэтэрсэн байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 231.0 сая төгрөгөөр буурахад гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд хөрөнгө шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.
- Урт хугацаат хөрөнгө оруулалт 5.1 сая төгрөгөөр өсөж 56.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Хоршоо хөгжүүлэн сангийн 1 жилээс дээш хугацааны дараа төлөгдөх зээлийн үлдэгдэл юм.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,392.9 сая төгрөгөөр буурахад гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.
- Орон нутгийн өмч 3,027.8 сая төгрөгөөр буурахад "Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн

тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд хөрөнгө шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 1,462.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 3,752.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №9 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү
Татварын орлого	198.8	332.7	177.4
Татварын бус орлого	1,089.7	394.3	-695.4
Тусламж санхүүжилтийн орлого	4,080.2	845.5	-3,234.6
Нийт дүн	5,375.8	1,623.1	-3,752.8

Эх сурвалж: Арбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Нийт орлогын дүн буурсан шалтгаан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын тайлан улсын төсөвт шилжсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын хоорондын тооцоогоор 1,037.0 сая төгрөгийн орлогын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар 4,458.2 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Хүснэгт №10: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү
Үйл ажиллагааны зардал	3,641.1	1,312.1	-2,329.0
Үйл ажиллагааны бус зардал	54.7	3,146.1	3,091.4
Нийт дүн	3,695.8	4,458.2	- 762.4

Эх сурвалж: Арбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Нийт зардлын дүн өссөн нь гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материалыг шилжүүлэхдээ үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын хоорондын тооцоогоор 1,037.0 сая төгрөгийн зарлагын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төслийг харьяа байгууллагуудын хүрээнд нэгтгэн боловсруулж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Арбулаг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 1,662.7 сая төгрөгийн төсөв баталснаас 1,320.3 сая төгрөгийг урсгал зардалд, 212.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, зээл олгоход 130.4 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 338.3 сая төгрөгийг орон нутгийн орлогоос, 114.4 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 727.3 сая төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 206.2 сая төгрөгийг давсан орлого дансны үлдэгдлээс, 133.4 сая төгрөгийг зээлийн эргэн төлөлт болон хүүгийн орлогоос тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Арбулаг сумын ИТХ-ын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 15 дугаар тогтоолоор нийт төсвийг 142.9 сая төгрөгөөр бууруулан тодотгол хийж 1,519.8 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр 1,229.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 1,326.5 сая төгрөгийн зардлыг зарцуулж, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 125.2 сая төгрөг байна. Төсвийн орлого бүрдүүлэлтийг харуулбал:

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Арбулаг сумын ИТХ-ын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 15 дугаар тогтоолоор Арбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 338.4 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 339.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 100.2 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №11. Сумын төсөвт төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

Орлогын нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү +/-	Хувь
Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	114.7	151.91	37.2	132%
ХХОАТ-ын буцаан олголт	0.00	-9.84	-9.84	-
Хувиараа аж ахуй эрхэлсний орлого	15.00	34.63	19.63	230%
Хөрөнгө борлуулсны орлого	1.09	3.51	2.42	322%
Хөрөнгийн орлого	20.00	13.87	-6.13	69.4%
Шууд бус орлого	1.00	6.13	5.13	613%
Үл хөдлөх хөрөнгийн татвар	1.00	0.48	-0.51	48%
Бууны албан татвар	4.10	2.91	-1.86	71%
Малын тоо толгойн татвар	129.00	59.81	-69.10	46%
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	12.90	42.16	29.26	326%
Улсын тэмдэгтийн хураамж	4.30	5.86	1.56	136%
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.21	0.10	-0.11	49%
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0.28	0.30	0.02	107%
Ойн нөөц ашигласны төлбөр	24.26	17.92	-6.34	73.9
Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	3.00	0.83	-2.17	28%
Газрын төлбөр	2.55	1.25	-1.30	46%
Газрын дуудлага худалдаа	0.00	0.89	0.89	-
Татварын орлогын дүн	333.39	332.72	-0.67	99.8
Торгуулийн орлого	5.00	6.43	1.43	129%
Татварын бус орлогын дүн	5.00	6.43	1.43	129%
Нийт орлогын дүн	338.39	339.15	0.76	100.2

Эх сурвалж: Арбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Арбулаг сумын орон нутгийн орлого 0.8 сая төгрөгөөр давж биелсэн байна. Үүнд Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын татвар 37.2 сая төгрөгөөр, Хувиараа аж ахуй эрхэлсний орлого 19.6 сая төгрөгөөр давж биелсэн зэрэг нь нөлөөлсөн байна.

Малын толгой тутмаас авах татварын орлогын төлөвлөгөө 69.1 сая төгрөгөөр, нийт 8 нэр төрлийн орлогын төлөвлөгөө тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 19.7 сая төгрөгөөр төлөвлөж 20.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 103.0 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №12: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	ААНОАТ /40/	0.7	0.0	-0.7
2	АТБӨЯХАТ	13.0	20.3	7.3
3	Зам ашигласны төлбөр	6.0	6.0	0.0

4 Нийт дүн	19.7	20.3	6.7
-------------------	-------------	-------------	------------

Эх сурвалж: Арбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 6.7 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 3.2 сая төгрөгөөр төлөвлөж 5.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 168.8 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №13: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	1.2	1.1	-0.1
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	1.2	1.0	-0.2
3	Агаарын бохирдлын төлбөр	0.8	3.3	2.5
4	Нийт дүн	3.2	5.4	2.2

Эх сурвалж: Арбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 2.2 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 1,509.5 сая төгрөгөөр төлөвлөж, 1,326.4 сая төгрөг буюу 87.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 133.4 сая төгрөгийг орлогыг оруулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 46.6 сая төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлтийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 1,509.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,003.7 сая төгрөгийг урсгал зардалд, 187.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 220.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,326.4 сая төгрөг буюу 87.8 хувьтай байгаа нь . Төсвийг гүйцэтгэл 87.8 хувь байгаа нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн төлөвлөгөө 86.8 сая төгрөгөөр дутуу биелсэн, малын тоо толгойн татварын орлого 69.1 сая төгрөгөөр дутуу биелж ОНХС-ийн санхүүжилт хийгдээгүй зэргээс шалтгаалсан байна. Урсгал зардлын хэмнэлтийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 5.6 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 0.3 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 0.5 сая төгрөг
- Хөрөнгийн зардал 12.2 сая төгрөг

Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны гүйцэтгэлийн талаар:

ИТХ-ын 2021 оны 12 сарын 17-ны 11 дүгээр тогтоолоор ОНХС-ийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах 35 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс шилжих хөрөнгө оруулалтаар 1 төсөл арга хэмжээ, шинээр эхлэх 34 төсөл, арга хэмжээнд нийт 342.4 сая төгрөгийн төсөв баталсан байна. Гүйцэтгэлээр 252.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар тендерийн орлого 0.3 сая төгрөг, хандив тусламжийн 4.1 сая төгрөг, статистикийн хэлтсээс мал тооллогын зардлын санхүүжилт 4.5 сая төгрөг нийт 8.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Дээрх нэмэлт санхүүжилтийн орлогуудыг удирдамж зориулалтын дагуу зарцуулж ажилласан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Арбулаг сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Арбулаг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 1/68 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,641.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 54.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 43.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлж нийт зардлын хэмжээ буурсан тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоов.

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,312.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 19.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувь буюу 15.7 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ТТЗ-ийн харьяа байгууллагуудын Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Арбулаг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 125.2 сая төгрөгийн 3 зөрчилд 3 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	3	125.2	3	125.2	100
Нийт дүн	3	125.2	3	125.2	100

Өмнөх онд хүргүүлсэн 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 169.7 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрсэн. Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлттэй холбоотой 1, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой 1, харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах 1 нийт 3 зөвлөмж хүргүүлж байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлогын данс болон харьяа 2 байгууллага, орон нутгийн 2 тусгай сангийн нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, бусад байгууллага, тусгай сангийн санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлын хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан Арбулаг ЗДТГ-ын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4.3 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрсэн. Аудитаар илэрсэн зөрчилд үндэслэн 2.0 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өгч, 1.3 сая төгрөгийн 2 зөрчилд 2 зөвлөмж хүргүүлсэн байна.

5.1 Төлбөрийн акт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага, хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр авч үзвэл 8 нэр төрлийн 87.5 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, нэр төрөл бүрээр төлөвлөгөөг биелүүлж ажиллах.

2. Хугацаа хэтэрсэн зээлийн авлагатай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлсэн сангийн авлагын үлдэгдэл 254.0 сая төгрөг байна. Үүнээс 18 иргэний 113.5 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоо хөгжүүлэх сангийн журам”-ын 3.4.11.Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Сум хөгжүүлэх сангийн хугацаа хоцорсон зээл, хүүгийн үлдэгдлийг төвлөрүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх

3. ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн зөрчлийн талаар

3.1. Илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 4.3 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрсэн байна. Дээрх 3 зөрчилд 2.0 сая төгрөгийн 1 өгч, 1.3 сая төгрөгийн 2 зөвлөмжийг өгсөн байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Өөрийн хяналтад байдаг байгууллагуудын санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжүүдийг хяналтдаа авч хэрэгжилтийг хангуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 4.3 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрсэн байна. Дээрх 3 зөрчилд 2.0 сая төгрөгийн 1 өгч, 1.3 сая төгрөгийн 2 зөвлөмжийг өгсөн байна.	1						1					
Хоршоо хөгжүүлсэн сангийн авлагын үлдэгдэл 254.0 сая төгрөг байна. Үүнээс 18 иргэний 113.5 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн байна.	1	113.5					1	113.5				
Орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр авч үзвэл 8 нэр төрлийн 87.5 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна.	1	87.5					1	87.5				
Дүн	3	201.0					201.0					
Харьяа байгууллагуудын зөрчил												
Арбулаг сумын Засаг даргын Тамгын газар	2	1.3					2	1.3				
Арбулаг сумын ИТХ	1	2.0			1	2.0						
Дүн	3	4.3			1	2.0	2	1.3				

АУДИТЫН ТАЙЛАНГ;

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Л.МАНДАХНАРАН ОГНОО: